



## ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

Аймгийн Засаг даргын 2008 оны 04 сарын 13-ны өдрийн А/237 дугаар захирамжаар хүчингүйд тооцсон.

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ / Цахим тоглоомын газрын ажиллах журам /

2008 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр Сайншанд

Дугаар 187

“Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 “ж”, “л” дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 324 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цахим тоглоомын газрын ажиллах журмыг хавсралтаар баталсугай.
2. Журмыг хэрэгжүүлэх ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулахыг сумын Засаг дарга нарт даалгасугай.
3. Журмын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газар /Т.Энхтүвшин/, Цагдаагийн газар /Ч.Батбаяр/-г тус тус үүрэг болгосугай.

ДАРГА Ж.БАТСУУРЬ

2008 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр улсын бүртгэлийн 2902 дугаарт бүртгэсэн